



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/79

Улаанбаатар хот

### “Солонгосын соёлын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.5, Нийслэлийн Засаг даргын 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/771 дугаар, 2018 оны 09 дүгээр 07-ны өдрийн А/830 дахь захирамж, тус газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Солонгосын соёл урлаг, тоглоом наадгай, хоол хүнс, эрүүл мэнд, гоо сайхны бүтээгдэхүүн үйлчилгээ, уламжлалыг олон нийтэд таниулах зорилгоор “Солонгосын соёлын өдрүүд” арга хэмжээг 2018 оны 9 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Сүхбаатар дүүрэг 3-р хороо, Сөүлийн гудамж /Гэрэлт гудамж/-нд зохион байгуулсугай.

2. “Солонгосын соёлын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Солонгосын соёлын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах ажилд шаардагдах 7.642.920 /долоон сая зургаан зуун дөчин хоёр мянга есөн зуун хорин/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Батцоож /-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, арга хэмжээний үеэр хамтран ажиллах гэрээ байгуулах байгууллагуудыг судалж, 2018 оны 09-р сарын 10-ны өдрөөс өмнө танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /В.Батчимэг/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500263


Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 09  
сарын 14 өдрийн А/79 дүгээр  
тушаалын нэгдүгээр хавсралт

5284525 СБТ 48926 1118263502

“СОЛОНГОСЫН СОЁЛЫН ӨДРҮҮД” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	В.Батчимэг	- Бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Б.Ишдорж	- Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний хөгжил хариуцсан мэргэжилтэн
	Ш.Ундармаа	-Соёлын аялал жуулчлал, салбарын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
	Э.Зоригт	-Маркетинг, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
	Б.Үржинханд	-Архив, бичиг хэргийн эрхлэгч, даргын туслах
Нарийн бичиг:	Н.Алтанзаяа	- Хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 09  
сарын 14 өдрийн А/79 дүгээр  
тушаалын хоёрдугаар хавсралт



**“СОЛОНГОСЫН СОЁЛЫН ӨДРҮҮД” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажлын нэр	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
<b>Бэлтгэл ажлын хүрээнд</b>			
1	Захирамжийн төсөл бэлтгэх, батлуулах	2018.09.07	В.Батчимэг
2	Асар түрээслэх гэрээ хийх	2018.09.13	В.Батчимэг
3	Тайз, дэлгэц, хөгжим, техник тоног төхөөрөмж түрээслэх гэрээ хийх	2018.09.13	В.Батчимэг
4	Арга хэмжээний үеэр хамтран ажиллах байгууллагууд руу албан бичиг явуулах, хуваарийг авч танилцуулах	2018.09.10	Н.Алтанзаяа
5	Шаардлагатай утасны жагсаалт бэлтгэх, арга хэмжээний үеэр ажиллах хүмүүст өгөх	2018.09.14	Н.Алтанзаяа
6	Арга хэмжээний нээлтэнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хэлэх үгийг бэлтгүүлэх	2018.09.14	Э.Зоригт
7	Арга хэмжээний хөтөлбөр мэдээллийг аялал жуулчлалын байгууллагууд руу явуулах, хэвлэл мэдээллээр сурталчилах	2018.09.10-16	Н.Алтанзаяа Э.Зоригт
<b>Арга хэмжээний өдрүүдэд</b>			
8	Гэрэлт гудамжны цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол явуулах тал дээр холбогдох байгууллагатай холбогдон ажиллах, цэвэрлэгээг тогтмол хийлгэх, арга хэмжээ дууссаны дараа цэвэрлэгээг бүрэн хийлгэх	2018.09.15-16	Б.Ишдож
9	Тайз, дэлгэц тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хариуцан ажиллах	2018.09.15-16	Э.Зоригт, В.Батчимэг
10	Хэвлэлийн мэдээг арга хэмжээнд ирсэн хэвлэл мэдээллийнхэнд өгч ажиллах	2018.09.15-16	Э.Зоригт, Ш.Ундармаа
11	НОБГ, НМХГ, НЦГ-ын ажилтнуудад арга хэмжээний талаар мэдээлэл өгч ажиллах	2018.09.15-16	Н.Алтанзаяа
12	Богино холбооны станцуудыг холбогдох ажилтнуудад хүлээлгэн өгөх, хариуцах	2018.09.15-16	Б.Үржинханд
13	Арга хэмжээний үеэр зураг авах /арга хэмжээ, тайз, лед, гэрэлтүүлэг, асар г.м/	2018.09.15-16	Б.Үржинханд
13	Тайзны хөтөлбөрийг хариуцан ажиллах /хөтөлбөрийн дагуу/	2018.09.15-16	В.Батчимэг, Н.Алтанзаяа
14	Цахилгааны эх үүсвэрийн асуудал, аюулгүй байдлыг хариуцан ажиллах	2018.09.15-16	Монгол наадам цогцолбор н.Солонго

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 09  
сарын 14 өдрийн А/79 дүгээр  
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ 8926 1118263502

“СОЛОНГОСЫН СОЁЛЫН ӨДРҮҮД” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз засалт, карказ, техник			6.042.920	6.042.920
2	Асар, майхан түрээс	Ширхэг	20	80.000	1.600.000
ДҮН				7.642.920	